



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 15/1, Утас: 26-08-55, Факс: (976-51) 26-37-39,
E-mail: gro@prokuror.mn

2015-09-03 № 5/3244

танай _____-ны № _____-т

ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА Л.ЧУЛУУНБААТАР ТАНАА

Улсын Ерөнхий прокурорын 2015 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн А/91 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан "Прокурор хилийн хориг тавих, цуцлах журам"-ыг хүргүүлэв.

Энэхүү журмыг харъяа газар, хэлтсүүдэд хүргүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана уу.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ,
ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ
ХЭЛТСИЙН ДАРГА



Е.САГСАЙ

0605240



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Прокурорын байгууллагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6 дахь хэсгийг удирдлага болгон ТУШААХ нь:


1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Прокурор хилийн хориг тавих, цуцлах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Аймаг, Нийслэл, Тээвэр, Дүүргийн прокурор, Сум дундын ахлах прокуроруудад үүрэг болгосугай.

3. Энэ тушаалыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад хүргүүлж, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж байхыг Хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс /Е.Сарсай/, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс /Ц.Мөнхбат/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Зааварт өөрчлөлт оруулах тухай" Улсын Ерөнхий прокурорын 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн А/52 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.


УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ



М.ЭНХ-АМГАЛАН

0601162

Улсын Ерөнхий прокурорын
2015 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн
А/91 дугаар тушаалын хавсралт



ПРОКУРОР ХИЛИЙН ХОРИГ ТАВИХ, ЦУЦЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1. Прокурор хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх явцад сэжигтэн, яллагдагчид хилийн хориг тавих, түүнийг цуцлах ажлыг явуулахдаа Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалт, энэ журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Хилийн хориг тавих, цуцлах ажиллагаа:

1. Эрх бүхий байгууллагын хүсэлтийг үндэслэн эрүүгийн хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан этгээд нь улсын хилээр нэвтэрч болзошгүй хангалттай баримт байна гэж үзвэл хэргийг шийдвэрлэх хүртэл хугацаанд гадаадад зорчих эрхийг нь түр түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

2. Хилийн хориг тавих, цуцлах асуудлыг тухайн хэрэгт хяналт тавьж буй прокурорын саналыг үндэслэн дээд шатны прокурор нь Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт албан бичиг хүргүүлэн, энэ тухай сэжигтэн, яллагдагч, түүний өмгөөлөгчид мэдэгдэнэ.

3. Албан бичигт эрүүгийн хэргийн дугаар, холбогдуулан шалгаж байгаа хуулийн зүйл, хэсэг, сэжигтэн, яллагдагчийн ургийн овог, эцэг /эх/, өөрийн нэр, регистр, гадаад паспортын дугаар, иргэншил, /гадаадын иргэн бол овог, өөрийн нэрийг латин үсгээр бичих/, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж буй үндэслэл зэргийг тодорхой дурьдана.

4. Гадаадад зорчих эрхийг нь түдгэлзүүлсэн этгээд хувийн болон албан ажлаар гадаад улсад явах, эмчилгээ хийлгэх зэрэг зайлшгүй шаардлагаар уг шийдвэрийг түр хугацаагаар цуцлах талаар хүсэлт гаргавал прокурор хянаж, үндэслэлтэй бол хилийн хоригийг тодорхой хугацаанд цуцлах талаар Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт албан бичиг хүргүүлнэ.

5. Дээрх тохиолдолд сэжигтэн, яллагдагчийг гадаад улсад оролцох холбогдох хурал, зөвлөлгөөний хөтөлбөр, урилга, виз, гэрээний төсөл, өөрөө болон гэр бүлийн гишүүд нь гадаад улсад эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон, гадаад улсад амьдарч буй гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садны хүн нь нас барсан, хүндээр

өвчилснийг нотолсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт, тодорхойлолт зэрэг шаардагдах баримтуудыг хүсэлтэнд заавал хавсаргасан байхыг шаардана.

6. Сэжигтэн, яллагдагчийг Монгол Улсын хилээр эргэн орж ирсэн үеэс эхлэн зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэрийг хэвээр үргэлжлүүлж, энэ тухай Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт прокурор албан бичгээр мэдэгдэнэ.

7. Прокурор хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоолд сэжигтэн, яллагдагчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох талаар дурьдах ба байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдоос уг шийдвэрт хуульд заасан хугацаанд гомдол гаргаагүй тохиолдолд нэн даруй хоригийг цуцлах талаар Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт албан бичиг хүргүүлнэ.

8. Хилийн хориг тавигдсан сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.2 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр түдгэлзүүлсэн тохиолдолд хоригийг цуцлах эсэхийг хэрэгт хяналт тавьж буй прокурор шийдвэрлэнэ.

9. Амралтын болон ажлын бус цагаар хойшлуулшгүй тохиолдолд эрх бүхий байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийн талаарх мэдээ, мэдээллийг жижүүрийн прокурорт мэдэгдэнэ. Жижүүрийн прокурор нь Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газарт хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх талаар харилцаа, холбооны хэрэгслийг ашиглан мэдэгдэх бөгөөд уг ажиллагааг явуулсан тохиолдолд 24 цагийн дотор прокурорын зөвшөөрөл бүхий албан бичгийг нөхөн хүргүүлж баталгаажуулна.

10. Хилийн хориг тавьсан, цуцалсан тухай албан бичгийн хувийг хэргийн материалд хавсаргаж, прокурорын яллах дүгнэлтийн хавсралтанд энэ тухай дурьдана.

11. Хилийн хориг тавьсан, цуцалсан сэжигтэн, яллагдагчийн талаарх мэдээллийг цахим болон зохих зааварт заасан бүртгэлд заавал бүртгэнэ.

12. Торгох, албадан ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах ял шийтгүүлсэн ялтныг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан болон албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон, хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан, Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд заасан үндэслэлээр тэнсэгдсэн ялтанд хилийн хориг тавих талаар гаргасан Цагдаагийн байгууллагын саналыг ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж буй прокурор хянаж, дээд шатны прокурорт танилцуулан хилийн хориг тавих тухай албан бичгийг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлнэ.

13. Торгох, албадан ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах ял шийтгүүлсэн, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан болон албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон, хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан, Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд заасан үндэслэлээр тэнсэгдсэн ялтан өөрөө болон гэр бүлийн гишүүд нь гадаад улсад эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон, гадаад улсад амьдарч буй гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садны хүн нь нас барсан, хүндээр өвчилснийг нотолсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт, тодорхойлолтыг үндэслэн хилийн хоригийг түр хугацаагаар түдгэлзүүлж болно.

14. Ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл гадаадын иргэнийг Монгол Улсын Олон Улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллагын саналыг ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж буй прокурор хянаж дээд шатны прокурорт танилцуулан хилийн хориг тавих, цуцлах тухай албан бичгийг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлнэ.

15. Хилээр нэвтрэх хориг тавигдсан ялтны талаарх мэдээллийг Улсын Ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн нэгдсэн бүртгэлд авч, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хяналт хариуцсан прокурор хариуцаж гүйцэтгэнэ.